Эдгээр барилга байгууламжийн 43.0 хувь нь төрийн, 57.0 хувь нь иргэний болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдаж байна. Ашиглалтанд орсон барилга, байгууламжийн гүйцэтгэлийн 68.8 хувийг орон сууцны барилга, 24.0 хувийг орон сууцны бус барилгын ажил, 7.2 хувийг инженерийн барилга байгууламжийн ажил тус тус эзэлж байна.

Хүснэгт 17. Ашиглалтанд орсон барилга, оны эхний 9 сард, сая төгрөг

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016			2017		
		Нийт	Үүнээс:		Нийт	Үүнээс:	
			Хүчин чадал (хэмжээ)	Өртөг (сая төгрөг)		Хүчин чадал (хэмжээ)	Өртөг (сая төгрөг)
Орон сууцны барилга	айл	99	10297	492 157.6	89	10739	675 016.0
Үйлдвэрийн	м ²	7	17347	4 500.0	2	2638	10 687.6
Худалдаа, үйлчилгээний	м ²	40	156373	74 847.0	23	81634	56 558.6
Эмнэлэг	орны тоо	3	120	2 900.0	3	1292	4 850.0
Цэцэрлэг	хүүхдийн тоо	11	2400	20 052.5	11	1630	16 971.7
Сургууль	хүүхдийн тоо	10	4690	21 287.4	8	8490	60 650.0
Спорт, биеийн тамир	-	6	-	9 184.5	2	-	5 524.0
Конторын	м ²	22	93488	62 197.0	7	19197	21 818.0
Зочид буудал	-	-	-	-	4	523	58 800.0
Эрчим хүчний	-	130	-	58 744.7	113	-	30 085.0
Холбооны	-	2	-	368.9	3	-	1 055.0
Авто зам засвар, шинэчлэл	-	15	-	30 167.7	2	-	8 900.0
Төмөр бетон гүүр, гүүрэн гарц	-	8	-	52 787.0	2	-	3 915.3
Далан, суваг, шугам	-	12	-	17 166.7	5	-	12 636.8
Бусад	-	24	-	17.368.7	69	-	13 807.7
Нийт		389		863 729.7	343		981 275.7



НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


2017 оны эхний 9 сард Нийслэлийн Тээврийн газраас Улаанбаатар хотын дотор болон хот орчимд 3.8 мянга гаруй км урттай, 127 чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулжээ.

Нийтийн тээврийн үйлчилгээний “үндсэн чиглэл”-ийн тоо өмнөх оны мөн үеэс 8.7 хувиар, хот доторх автобусны чиглэлийн урт 5.9 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 25. Зорчигч тээврийн чиглэлийн тоо




Зураг 26. Зорчигч тээврийн чиглэлийн урт



2017 оны эхний 9 сард Улаанбаатар хотын хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээг 39 аж ахуйн нэгж эрхлэн явуулсан нь өмнөх оны мөн үеэс 2 аж ахуйн нэгжээр цөөрсөн байна. Тухайлбал, бага, дунд багтаамжийн автобусаар үйлчлэгч аж ахуйн нэгжийн тоо 11.1 хувиар, такси үйлчилгээ эрхлэгчдийн тоо 15.4 хувиар буурчээ. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгжийн дийлэнх хэсгийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд эзэлсэн хэвээр байна.

Зураг 27. Зорчигч тээврийн үйлчилгээний салбарт ажиллаж буй ААН-ийн тоо



Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүд 2017 оны эхний 9 сард 488.9 сая хүн километрийн ажил үйлчилгээг гүйцэтгэн, давхардсан тоогоор нийтдээ 143.8 сая хүн тээвэрлэж, 59.5 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

Зорчигчдын тоо өмнөх оны мөн үеэс 36.7 сая (20.3%) хүнээр буурч, үйлчилгээний орлого 2.5 тэрбум (4.4%) төгрөгөөр өсчээ. Энэ нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалсан байна. Үүнд:

- Хөлс төлөлтийн цахим хэлбэрт шилжиж, зорчих тасалбар таслахгүйгээр кондукторгүй үйлчилгээг нэвтрүүлсэнээр зорчигчдын хөлс төлөлтөнд тавих хяналт суларсан.
- Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг нийслэлийн төсвөөс олгох болсноор үйлчилгээ эрхлэгчдийн хувьд шугамын орлогыг нэмэгдүүлэх, зорчигчдыг суулгах сонирхол буурч, үр ашиг багатай зорчилт хийх болсон.
- Чиглэл маршрутын шинэчилсэн төлөвлөлтийн хүрээнд зүүн гарын эргэлт болон чиглэлийн давхцалыг бууруулах үүднээс зарим чиглэлийг богино эргэлтээр эргүүлэх болж, мөн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор шаардлагатай хэсгийн хүн урсгалын төвлөрөл, цэгүүдэд зогсоол буудлыг шийдэж өгөөгүйгээс иргэдийн нийтийн тээврийн үйлчилгээгээр зорчих эрэлтийг бүрэн хангаж чадахгүй байгаа нь зорчигчийн тоо буурахад голлон нөлөөлжээ.
- Эдгээрээс гадна цахим систем нь хөнгөлөлтөөр зорчигч иргэдийн “бодит зорчилт”-ыг бүрэн бүртгэж эхэлсэн нь нөхөн олговроор зорчигчдын тоог бууруулж, улмаар үйлчилгээний төлбөрт төрөөс олгодог нөхөн олговрын хэмжээг багасгах эерэг нөлөөг ч үзүүлэх болсон байна.


Хүснэгт 18. Нийтийн тээврийн үйлчилгээ, төлбөрийн хэлбэрээр, 2017 оны эхний 9 сард

Тээврийн хэрэгсэл, төрөл, өмчлөлөөр	Аж ахуйн нэгж (тоо)	Орлого (тэрбум төгрөг)	Төлбөр			Зорчигч (сая хүн)	Төлбөр		
			карт	бэлэн мөнгө	нөхөн олговор		карт	бэлэн мөнгө	нөхөн олговор
Зорчигч тээврийн нэгтгэл (ОНӨААТҮГ)	1	19.7	10.1	2.83	6.8	49.8	28.2	7.6	14.0
Автобус (хувийн)	18	39.1	20.1	3.75	15.3	92.3	53.1	9.9	29.3
Троллейбус (хувийн)	1	0.29	0.16	0.03	0.10	0.92	0.61	0.1	0.21
Бага багтаамжийн автобус	8	0.39	-	0.39	-	0.85	-	0.85	-
Дүн	28	59.5	30.3	7.0	22.2	143.8	81.9	18.4	43.5

Нийтийн тээврийн үйлчилгээний үндсэн үзүүлэлт болох тээсэн зорчигч болон үйлчилгээний орлогын зонхилох хэсэг нь их, дүнд багтаамжийн автобусны үйлчилгээнд ногдож байна. Тухайлбал, 2017 оны эхний 9 сард нийт 133.1 сая хүн (92.5%) их, дүнд багтаамжийн автобусаар зорчиж, үйлчилгээний нийт орлогын 93.6 хувийг бүрдүүлжээ. Цахилгаан тээврийн хувьд зорчигчдын 6.9 хувь, тээврийн орлогын 5.7 хувь нь тус тус ногдож байна.

2017 оны эхний 9 сард бүрдүүлсэн үйлчилгээний нийт орлогын 51.0 хувийг картын орлого, 11.7 хувийг бэлэн мөнгө, 37.3 хувийг “нөхөн олговор”-ын орлого эзэлж байна.

Зураг 28. Зорчигчдын үндсэн үзүүлэлт, төлбөрийн хэлбэрээр, 2017 оны эхний 9 сард



Нийтийн тээврээр зорчигчдын 56.9 хувь нь цахим картаар үйлчлүүлсэн байхад 12.9 хувь нь бэлэн мөнгө төлж зорчсон байна. Хөлс төлөлтийн цахим картаар үйлчлүүлсэн нийт зорчигчдын 64.8 сая (79.1%) нь насанд хүрэгчид байхад “бэлэн мөнгө төлсөн” зорчигчдын 3.9 сая (21.5%) гаруй нь хүүхдүүд байна.

Мөн нийт зорчигчдын 30.2 хувь нь нөхөн олговрын хөнгөлөлтөөр зорчжээ. Өөрөөр хэлбэл, давхардсан тоогоор оны эхний 9 сард нийтийн тээврийн хэрэгслээр 43.5 сая хүн үнэ төлбөргүй үйлчлүүлж, эдгээр хүмүүсийн үйлчилгээний төлбөрт төрөөс 22.2 тэрбум төгрөгийг тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд нөхөн олговор хэлбэрээр шилжүүлсэн байна.


Зураг 29. Дамжин суултаар зорчигчид, хувь




Цахим системийн бүртгэлээр зорчигчдын 15.6 хувийг ахмад настнууд, 5.2 хувийг оюутнууд эзэлж байгаа бол 8.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

2017 оны эхний 9 сард тээвэрлэсэн нийт зорчигчдын 5.4 сая (3.8%) нь дамжин суултаар зорчилт хийсэн байна. Тухайлбал, цахим картаар үйлчлүүлсэн 4.4 сая хүний 66.5 хувийг насанд хүрэгчид эзэлжээ. Харин нөхөн олговрын хөнгөлөлт эдэлж, дамжин суулт хийсэн зорчигчдын 11.7 хувь нь ахмад настнууд, 6.3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байв.

Зураг 30. Зорчигчдын тоо, сая хүн, төлбөрийн хэлбэрээр



Зураг 31. Үйлчилгээний орлого, тэрбум төгрөг, төлбөрийн хэлбэрээр



Нийтийн тээврийн парк шинэчлэлт 2017 оны эхний 9 сард нийтдээ 250 тээврийн хэрэгслээр хийгдсэний 96.4 хувийг “нөхөн хангалт” (их багтаамжийн хуучин 80 автобус, 153 такси, 2 троллейбус, дунд багтаамжийн 6 автобус) эзэлж байгаа бөгөөд дунд багтаамжийн 9 шинэ автобус үйлчилгээнд шинээр нэмэгджээ.

Харин стандартын шаардлага хангахгүй болж 12-оос дээш жилээр ашиглагдаж хуучирсан 290 тээврийн хэрэгсэл (их багтаамжийн хувийн хэвшлийн 146, бага багтаамжийн 27 автобус, 117 такси) үйлчилгээнээс хасагдсан байна.

Хүснэгт 19. Нийтийн тээврийн хөдлөх бүрэлдэхүүн


Дансны хөдлөх бүрэлдэхүүн		2016 I-IX	2017 I-IX
Бүгд		1861	2016
Их багтаамжийн автобус	Төрийн өмч	319	270
	Хувийн өмч	857	827
Дунд багтаамжийн автобус	Төрийн өмч	-	30
	Хувийн өмч	-	9
Троллейбус	Төрийн	41	42
	Хувийн	8	8
Угсраа автобус		20	20
Бага, дунд багтаамжийн автобус (хувийн)	Туслах чиглэл	33	26
	Буухиа чиглэл	19	175
Такси		564	609

Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ нь зориулалтын 2016 хөдлөх бүрэлдэхүүнтэй ажиллажээ. Эдгээрийн 11.9 хувь нь бага, дунд багтаамжийн автобус, 55.4 хувь нь их багтаамжийн автобус, 30.2 хувь нь такси байна.

Шугаманд өдөрт дунджаар их, дунд багтаамжийн 893 автобус, 16 угсраа автобус, 37 троллейбус, бага багтаамжийн 196 автобус ажиллажээ.


Шугаманд өдөрт ажилласан нийт тээврийн хэрэгслийн 75.6 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгсэл эзэлж байна.

Зураг 32. Өдөрт ажилласан тээврийн хэрэгсэл, тоо



Нийслэлийн Тээврийн газраас аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан “Нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн гүйцэтгүүлэх тухай гэрээ”-гээр насанд хүрэгчид их, дунд багтаамжийн автобусаар 500 төгрөг, цахилгаан тээврээр 300 төгрөг, туслах болон буухиа чиглэлийн бага багтаамжийн автобусаар 500-1300 төгрөг, хот орчмын чиглэлийн бүх төрлийн автобусаар 500-2300 төгрөгөөр (хүүхэд 200-1200 төгрөг) зорчиж байна. Мөн тус гэрээнд таксины үйлчилгээний нэг төлбөрт километрийн тарифыг 1000 төгрөгөөр тогтоож, үйлчилгээнд мөрдүүлэхээр заасан байна.

Зураг 33. Хүлээлтийн хугацаа, минут




Зогсоолд ирэх автобус хоорондын зай буюу нийтийн тээврийн хүлээлтийн дундаж хугацааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бага багтаамжийн автобусны хүлээлт 7.8 минутаар нэмэгдэж, их багтаамжийн автобусных 0.8 минутаар буурч, угсраа автобус болон цахилгаан тээврийн хүлээлтийн хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

2017 оны эхний 9 сард нийслэлийн зорчигч тээврийн үйлчилгээний талаар иргэдээс дараах төрлийн нийт 2458

санал, гомдол Нийслэлийн Тээврийн газарт ирүүлсэний 89.5 хувийг нь шийдвэрлэж, барагдуулсан байна.

Зураг 34. Үйлчилгээний талаар ирүүлсэн санал, гомдлын барагдуулалт



Зураг 35. НТ-ийн үйлчилгээний талаарх санал, гомдол, оны эхний 9 сард






ХАРИЛЦАА ХОЛБОО


Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээний нийт орлого 2017 оны эхний 9 сард 555.5 тэрбум төгрөг, хүн амаас орсон орлого 388.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс салбарын нийт орлого 12.9 тэрбум (3.6%) төгрөг, хүн амаас орсон орлого 5.4 тэрбум (0.9%) төгрөгөөр өсчээ. Шуудан, холбооны салбарын нийт орлогын 70.0 хувийг нийслэлийн хүн амд үзүүлсэн үйлчилгээнээс бүрдүүлсэн байна.

Зураг 36. Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээний орлого




2017 оны эхний 9 сард нийслэлийн хэмжээнд суурин телефон цэгийн тоо 265.5 мянга болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.6 хувиар нэмэгджээ. Нийт суурин телефон цэгийн 228.6 мянга (86.1%) нь айл өрхийн эзэмшилд байна. Нийслэлд телефон утас эзэмшигч өрхийн тоо өмнөх оны мөн үеэс 12.7 хувиар өсчээ. Үүнд гурвалсан үйлчилгээний суурин утасны үйлчилгээг хэрэглэгчдийн тоо өсөн нэмэгдэж байгаа нь голлон нөлөөлж байна.

Зураг 37. Суурин телефон цэгийн тоо



Зураг 38. Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо




2017 оны эхний 9 сард Монгол Улсын хэмжээнд давхардсан тоогоор нийт 3.6 сая хүн үүрэн телефоны хэрэглэгч (идэвхтэй) байгаагийн 1.7 сая (47.5%) хэрэглэгч нь нийслэл хотод байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үүрэн телефоны идэвхтэй хэрэглэгчийн тоо нийслэлд 41.9 мянгаар буурчээ.

Үүрэн холбооны нийт хэрэглэгчдийн 412.3 мянга нь дараа төлбөрт үйлчилгээний, 1322.4 мянга нь урьдчилсан төлбөрт үйлчилгээний хэрэглэгчид байна.

Хөдөлгөөнт утасгүй телефон буюу WLL үйлчилгээний хэрэглэгчдийн тоо 0.5 мянга болж өмнөх оны мөн үеэс 38 хэрэглэгчээр буурсан байна. Нийслэлд 0.3 мянга орчим хэрэглэгч сансарын холбоог эзэмшиж байна.

Зураг 39. КаТВ-ийн сувагт холбогдсон хэрэглэгчийн тоо



Кабелийн болон Ай Пи телевизийн 18 аж ахуйн нэгж байгууллага нийслэлийн 395.1 мянга гаруй хэрэглэгчдэд үйлчилж байна. Кабелийн сувагт холбогдсон нийт хэрэглэгчдийн 94.7 хувийг айл өрх эзэлдэг байна.

Кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт аж ахуйн нэгжийн 16 нь нийслэлийн төвийн 6 дүүрэгт, 2 нь Налайх дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.



ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ


2017 оны эхний 9 сард нийслэлийн хүн амд 27.1 сая.м³ (78.3%) аж ахуйн нэгж, байгууллагад 7.5 сая.м³ (21.7%) цэвэр усыг борлуулжээ. Борлуулсан усны нийт хэмжээ өмнөх оны мөн үеэс 4.9 хувиар өссөн байна.

Хүн амд түгээсэн цэвэр усны 96.1 хувь буюу 26.1 сая.м³ усыг төвлөрсөн шугамаар, 1038.5 мян.м³ усыг ус түгээх байраар, 7.5 мян.м³ усыг тээврээр түгээсэн байна. Цэвэрлэх байгууламжаар 44.0 сая.м³ бохирыг цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 34.6 сая.м³ бохир шингэнийг татан зайлуулсан байна.


Хүснэгт 20. Ус суваг ашиглалтын үйлчилгээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2013	2014	2015	2016	2017	2017 / 2016 %
Шахсан ус	мян.м ³	41 539.2	40 399.0	39 130.6	39 210.4	39 043.9	99.6
Борлуулсан ус	мян.м ³	33 174.2	33 755.7	33 184.8	33 049.9	34 653.1	104.9
Хүн амд	мян.м ³	24 536.9	24 402.0	24 834.0	25 218.2	27 149.7	107.7
Аж ахуйн нэгж, байгууллагад	мян.м ³	8 637.3	9 353.7	8 350.8	7 831.7	7 503.4	95.8
Татан зайлуулсан бохир	мян.м ³	32 577.1	32 889.8	32 390.3	33 018.0	34 626.8	104.9
Хүн амаас	мян.м ³	22 872.0	22 632.9	23 026.7	24 317.5	26 128.9	107.4
Аж ахуйн нэгж, байгууллагаас	мян.м ³	9 705.1	10 256.9	9 363.6	8 700.5	8 497.9	97.7
Ус борлуулалтын орлого	сая төг	11 831.6	13 815.2	19 425.8	19 176.8	20 949.3	109.2
Хүн амаас	сая төг	6 940.5	7 691.8	11 417.3	11 433.1	12 364.0	108.1
Аж ахуйн нэгж, байгууллагаас	сая төг	4 891.1	6 123.4	8 008.5	7 743.7	8 585.3	110.9
Сувагжуулалтын орлого	сая төг	6 612.3	7 849.8	11 601.9	12 840.2	14 188.2	110.5
Хүн амаас	сая төг	3 367.2	3 633.2	5 133.9	5 921.5	6 375.8	107.7
Аж ахуйн нэгж, байгууллагаас	сая төг	3 245.1	4 216.6	6 468.0	6 918.7	7 812.4	112.9

Зураг 40. Борлуулсан ус, сараар, мян.м3




Зураг 41. Татан зайлуулсан бохир, сараар, мян.м3



МАЛ ТӨЛЛӨЛТ, ТӨЛ БОЙЖИЛТ

Нийслэлийн хэмжээнд 2017 оны эхний 9 сард хээлтэгч нийт малын 167.7 мянган (81.4%) хээлтэгч төллөжээ. Нийт 167.9 мянган төл гарснаас 3851 нь хорогдож, 164.1 мянган төл бойжиж, бойжилт 97.7 хувьтай байна. Мал төллөлтийн мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад төллөсөн хээлтэгч 4056 (2.5%) толгойгоор, бойжсон төл 3491 (2.2%) толгойгоор, төлийн хорогдол 757 (24.5%) толгойгоор тус тус өсчээ.

Зураг 42. Мал төллөлт, төл бойжилт, эхний 9 сард, мянган толгой



Бойжуулсан нийт төлийн 5.8 хувийг унага, 17.6 хувийг тугал, 45.6 хувийг хурга, 31.0 хувийг ишиг эзэлж байна.

Хүснэгт 21. Мал төллөлт, эх малын төрлөөр, эхний 9 сард

Эх малын төрөл	Төллөсөн хээлтэгч, тоо, толгой				Төллөлтийн хувь			
	2014 I-IX	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	2014 I-IX	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX
Бүгд	139 503	166 221	163 653	167 709	91.5	92.1	87.1	81.4
Гүү	6 728	8 483	8 860	9 648	73.9	80.7	76.4	64.7
Үнээ	27 208	31 962	29 827	29 410	88.4	88.6	74.9	69.4
Ингэ	22	42	22	28	75.9	76.4	27.8	31.8
Эм хонь	61 679	72 188	72 225	76 286	95.3	92.7	91.3	87.9
Эм ямаа	43 866	53 546	52 719	52 337	91.6	95.6	91.9	84.6

Хүснэгт 22. Мал төллөлт, төл бойжилт, дүүргээр, эхний 9 сард

Дүүрэг	Төллөсөн хээлтэгч	Гарсан Төл	Хорогдсон төл	Бойжсон Төл	Төл бойжилт
Нийслэлийн дүн	167 709	167 924	3 851	164 073	97.7
Багануур	72 567	72 583	1 797	70 786	97.5
Багахангай	8 916	8 916	16	8 900	99.8
Баянзүрх	21 325	21 326	1 401	19 925	93.4
Налайх	19 927	19 927	143	19 784	99.3
Сонгинохайрхан	32 384	32 575	254	32 321	99.2
Сүхбаатар	967	967	27	940	97.2
Хан-Уул	11 062	11 069	213	10 856	98.1
Чингэлтэй	561	561	-	561	100.0

Хүснэгт 23. Төл бойжилт, төлийн төрлөөр, эхний 9 сард

Төлийн төрөл	Бойжуулсан төл, тоо, толгой				Бойжилтын хувь			
	2014 I-IX	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	2014 I-IX	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX
Бүгд	137 420	163 855	160 582	164 073	98.5	98.5	98.1	97.7
Унага	6 535	8 247	8 732	9 476	97.1	97.2	98.6	98.2
Тугал	26 861	31 538	29 217	28 877	98.7	98.7	98.0	98.2
Ботго	19	42	22	28	86.4	100.0	100.0	100.0
Хурга	60 937	71 421	71 140	74 754	98.8	98.9	98.5	97.8
Ишиг	43 068	52 607	51 471	50 938	98.1	98.1	97.6	97.2

Том малын зүй бус хорогдол :

2017 оны эхний 9 сард 5140 толгой том мал, зүй бусаар хорогдож, өмнөх оны мөн үеэс 41.5 хувиар өсчээ. Хорогдсон нийт малын 10.8 хувийг адуу, 20.7 хувийг үхэр, 34.2 хувийг хонь, 34.3 хувийг ямаа эзэлжээ. Том малын зүй бус хорогдлын 636 (12.4%) нь өвчнөөр, 1180 (23.0%) нь хээлтэгч малын хорогдол байна.

Хүснэгт 24. Том малын зүй бус хорогдол, төрлөөр, эхний 9 сард

Эх малын төрөл	Том малын зүй бус хорогдол					
	2012 I-IX	2013 I-IX	2014 I-IX	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX
Бүгд	1 923	2 912	1 754	1 977	3 632	5 140
Тэмээ	4	1	1	-	-	-
Адуу	237	186	122	164	108	556
Үхэр	289	396	266	292	889	1 061
Хонь	712	1 263	663	725	1 543	1 758
Ямаа	681	1 066	702	796	1 092	1 765

Хүснэгт 25. Том малын зүй бус хорогдол, дүүргээр, эхний 9 сард

Дүүрэг	Бүгд	Үүнээс :				
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Нийслэлийн дүн	5 140	-	556	1 061	1 758	1 765
Багануур	2 426	-	247	257	903	1 019
Багахангай	170	-	0	30	59	81
Баянзүрх	661	-	183	138	173	167
Налайх	582	-	38	104	272	168
Сонгинохайрхан	534	-	4	359	80	91
Сүхбаатар	58	-	4	32	9	13
Хан-Уул	706	-	80	141	259	226
Чингэлтэй	3	-	0	0	3	0

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн мэдээ:

Багануур дүүргийн түүхий эдийн захын дундаж үнээр нас гүйцсэн адуу 400000 төгрөг, үхэр 720000 төгрөг, эр хонь 175000 төгрөг, эм хонь 130000 төгрөг, ямаа 75000-85000 төгрөгийн ханштай байв.


Хүснэгт 26. Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ, төгрөгөөр

Төрөл	2014		2015		2016		2017	
	VIII	IX	VIII	IX	VIII	IX	VIII	IX
Тэмээний шир	13 000	12500	19 000	21500	16 500	16500	14 000	12500
Адууны шир	25 000	25500	34 333	28667	26 000	35000	18 000	18667
Үхрийн шир	55 000	58000	52 667	48333	27 000	30000	33 333	34000
Хонины арьс	6 500	6000	2 167	1833	2 000	3000	3 250	4000
Ямааны арьс /ноолуургүй/	4 000	7000	2 833	3667	750	1500	1 000	2000
Ямааны ноолуур	70 000	67000	50 000	51000	45 000	45000	55 500	75000

2017 оны 9-р сарын 28-ны өдрийн үнийн ажиглалтаар “Хүчит шонхор” зах дээр нэг кг тэмээний мах 4200 төгрөг, “Далай ээж” зах дээр гахайн мах 6500 төгрөг, тахианы мах 5500 төгрөгийн ханштай байна.

Нийслэлийн түүхий эдийн захуудын сарын дундаж үнээр тэмээний шир 12500 төгрөг, адууны шир 18667 төгрөг, үхрийн шир 1.8-2.3 метр урттай бол 20000 төгрөг, 2.3 метрээс дээш урттай нь 34000 төгрөг, хонины нэхий 4000 төгрөг, ямааны ноолуур 75000 төгрөгийн ханштай байна.

Зураг 43. Ямааны ноолуурын дундаж үнэ, төгрөг, 9-р сард



ГАЗАР ТАРИАЛАН

Ургац хураалтын мэдээгээр нийслэлийн хэмжээнд 117.4 га талбайгаас 695.2 тонн төмс, 194.8 га талбайгаас 2129.3 тонн хүнсний ногоо хураан авч, 2100.8 тонн өвс хадлан, 38.0 тонн тэжээлийн ургамал бэлтгэсэн байна.


Хүснэгт 27. Ургац хураалт, тонн, эхний 9 сард

Дүүрэг	Төмс	Хүнсний ногоо	Үүнээс :		Өвс хадлан	Тэжээлийн ургамал
			Өргөст хэмх	Улаан лооль		
Нийслэлийн дүн	695.2	2 129.3	440.8	327.7	2 100.8	38.0
Багануур	118.6	56.8	4.2	0.7	736.0	38.0
Багахангай	8.2	5.5	0.5	0.2	82.3	-
Баянгол	9.0	205.0	106.3	90.2	-	-
Баянзүрх	25.1	34.5	6.4	2.2	1.0	-
Налайх	110.9	94.4	10.4	4.5	1 281.5	-
Сонгинохайрхан	177.0	1 073.8	213.5	192.5	-	-
Сүхбаатар	5.9	11.6	4.2	2.2	-	-
Хан-Уул	211.0	624.9	94.0	35.0	-	-
Чингэлтэй	29.5	22.8	1.3	0.2	-	-

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төмс 668.2 (49.0%) тонноор, хүнсний ногоо 1039.6 (32.8%) тонноор, өвс хадлан 1059.5 (33.5%) тонноор тус тус буурсан байна.

Нийслэлийн хэмжээнд хураан авсан нийт ургацын 30.0 хувийг Налайх, 25.2 хувийг Сонгинохайрхан, 19.1 хувийг Багануур, 16.8 хувийг Хан-Уул, 8.9 хувийг бусад дүүргүүд тус тус эзэлж байна.

Зураг 44. Ургац хураалт, тонн, эхний 9 сард




АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж хэм 2017 оны 9-р сард дунджаар $+9.7^{\circ}\text{C}$ байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 0.9°C -аар хүйтэн, олон жилийн дундажтай харьцуулбал 0.2°C -аар дулаан байлаа. Энэ сарын хамгийн дулаан хэм $+26.1^{\circ}\text{C}$, хамгийн хүйтэн хэм -6.1°C , хур тунадасны нийлбэр 48.1 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 14 метр секунд хүрчээ.

Хүснэгт 28. Агаарын бохирдолт, $\text{мг}/\text{м}^3$, 9-р сард²

Бодисын нэр	Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ	
Хүхэрлэг хий	SO ₂	0.050	234	0.028	-	0.005
Азотын давхар исэл	NO ₂	0.050	270	0.091	52	0.031
Тоосжилт	PM ₁₀	0.100	250	0.248	33	0.079
	PM _{2.5}	0.050	171	0.089	7	0.024
Нүүрстөрөгчийн дутуу исэл	CO	10.000	651	3.206	-	0.554
Озон	O ₃	0.100	475	0.096	-	0.034

Зураг 45. Улаанбаатар³ хотын агаар дахь хүхэрлэг хийн агууламж, 12 харуулын дундаж, сараар, ($\text{мг}/\text{м}^3$)




² Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

³ Багануур, Багахангай, Налайх дүүрэгт агаарын бохирдлыг хэмжих харуул цэг байхгүй.


2017 оны 9-р сард азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж Баруун 4 зам орчимд 27 удаа, 13-р хороолол орчимд 19 удаа, Хархорин зах орчимд 6 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.

10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Хархорин зах орчимд 17 удаа, 13-р хороолол орчимд 5 удаа, 32-ын тойрог орчимд 4 удаа, Баруун 4 зам орчимд 3 удаа, Нисэх, Толгойт, Телевиз болон Амгалан орчимд тус бүр 1 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Телевиз орчимд 5 удаа, Толгойт орчимд 2 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.


Зураг 46. Улаанбаатар³ хотын агаар дахь азотын давхар ислийн агууламж, 12 харуулын дундаж, сараар, (мг/м³)



Зураг 47. Улаанбаатар³ хотын агаар дахь нүүрстөрөгчийн дутуу исэл, 12 харуулын дундаж, сараар, (мг/м³)



Зураг 48. Улаанбаатар³ хотын агаар дахь 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж, 12 харуулын дундаж, сараар, (мг/м³)



Хүснэгт 29. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, 9-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл- Экспо төв	Баруун дөрвөн зам	1-р хороолол	13-р хороолол	32-ын тойрог	Офицеруу- дын ордон	Хархорин зах	Ургах наран хороолол	Нисэх	Толгойт	Телевиз	Амгалан
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	-	0.005	0.003	0.004	0.003	0.001	0.004	-	0.001	0.011	0.010	0.011
	Хамгийн их	-	0.016	0.006	0.012	0.011	0.002	0.012	-	0.003	0.028	0.014	0.024
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	30	30	29	30	22	30	-	6	28	6	23
Азотын давхар Исэл NO ₂	Дундаж	-	0.077	0.017	0.057	0.025	0.010	0.041	-	0.009	0.022	0.027	0.024
	Хамгийн их	-	0.091	0.033	0.072	0.036	0.020	0.059	-	0.012	0.041	0.045	0.042
	XXX*-с давсан хувь	-	100.0	-	76.0	-	-	23.0	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	27	30	25	30	22	26	-	30	27	30	23
Нүүрс- төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	0.325	0.675	-	0.676	0.623	-	0.434	-	0.312	0.593	0.775	0.570
	Хамгийн их	0.638	1.717	-	2.175	1.900	-	1.063	-	0.835	2.169	3.206	1.079
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	16	33	-	88	90	-	90	-	90	90	89	65
Тоос PM10	Дундаж	0.055	0.074	-	0.069	0.066	-	0.117	-	0.060	0.106	0.085	0.078
	Хамгийн их	0.085	0.108	-	0.128	0.248	-	0.216	-	0.127	0.238	0.213	0.143
	XXX*-с давсан хувь	-	10	-	17.0	14.0	-	57.0	-	5.0	2.0	3	3
	Хэмжилтийн тоо	20	29	-	29	29	-	30	-	30	30	30	23
Тоос PM2.5	Дундаж	-	0.020	-	0.018	-	-	-	-	0.020	0.035	0.029	0.020
	Хамгийн их	-	0.039	-	0.031	-	-	-	-	0.037	0.089	0.084	0.038
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	8	15	-
	Хэмжилтийн тоо	-	29	-	29	-	-	-	-	30	30	30	23
Озон O ₃ **	Дундаж	-	-	-	0.012	0.022	-	-	-	0.022	0.050	0.038	0.062
	Хамгийн их	-	-	-	0.029	0.042	-	-	-	0.031	0.084	0.069	0.096
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	-	-	88	53	-	-	-	90	90	89	65

*- Хүлцэх хэм хэмжээ, **- CO, O₃-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2017 оны IX сарын танилцуулга

Туул голын усны бохирдол :

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2017 оны 9-р сарын 6,7-ны өдрүүдэд хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд бохирдуулагч бодисын хэмжээ хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд нитридийн нэгдэл, эрдэс фосфорын хэмжээ хэвийн, хүчилтөрөгчийн хэмжээ горим алдагдаж бохирдолтой, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 1.5 дахин, амоны азот 4.0 дахин хүлцэх хэм хэмжээнээс давж, Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 30. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м³, 9-р сард³

Үзүүлэлт	Стандарт хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
		Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч	O ₂	≥6	8.40	5.42	Горим алдагдсан бохирдолтой
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	BХХ ₅	≤ 3	2.75	4.6	1.5 дахин
Нитридийн нэгдэл	NO ₂	≤ 0.02	0.001	0.009	Хэвийн
Амоны азот	NH ₄	≤0.5	0.11	1.98	4.0 дахин
Эрдэс фосфор	P	≤0.1	0.001	0.106	Хэвийн

Байгаль орчны зөрчил :

Нийслэлийн хэмжээнд 2017 оны эхний 9 сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 238 зөрчлийг илрүүлжээ. Илрүүлсэн нийт зөрчлийн 39.9 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 33.6 хувийг газрын зөрчил, 8.0 хувийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, 8.0 хувийг геодези зураг зүй, кадастрын зөрчил, 5.0 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 2.1 хувийг ойн зөрчил, 1.3 хувийг ургамал, хөрсний бохирдлын зөрчил, 1.3 хувийг бусад зөрчил, 0.8 хувийг ангийн зөрчил тус тус эзэлж байна. Илрүүлсэн нийт зөрчилд 46.5 сая төгрөгийн торгууль ногдуулжээ.

Хүснэгт 31. Байгаль орчны зөрчил, төрлөөр, эхний 9 сард

Илрүүлсэн зөрчил, төрлөөр	2016			2017		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (сая.төг)	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (сая.төг)
Бүгд	114	454	82.9	373	249	55.9
Ой	17	31	9.9	8	5	2.2
Ан, амьтан	7	14	1.3	4	3	3.7
Газрын	13	90	30.3	196	89	38.6
Ус	3	1	-	1	-	-
Ургамал, хөрсний бохирдол	6	11	0.8	3	3	0.2
Агаар, химийн хорт бодис	25	129	3.1	11	12	1.0
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	16	19	10.0	95	95	5.6
Геодези зураг зүй, кадастр	7	135	9.7	9	20	3.4
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	5	12	15.4	35	19	1.0
Бусад	15	12	2.4	11	3	0.2

⁴ Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори



ГЭМТ ХЭРЭГ

2017 оны эхний 9 сард 15202 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1165 (8.3%) хэргээр өсчээ.


Гэмт хэргийн илрүүлэлт 29.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 29.2 пунктээр доогуур байна. Гэмт хэргийн улмаас 4440 хүн гэмтэж осолдон, 408 хүн нас барж, төр ард иргэдэд 133.9⁴ тэрбум төгрөгийн хохирол учруулсны 55.5 тэрбум (41.4%) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Хүснэгт 32. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, төрлөөр, эхний 9 сард

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өсөлт, бууралт, 2016-2017	
	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	Тоо	Хувь
Хүний амь	80	58	74	16	27.6
Хүчин	10	110	146	36	32.7
Дээрэм	324	300	580	280	93.3
Хулгай	4458	4857	5723	866	17.8
Булаалт	146	120	52	- 68	- 56.7
Залилан	1307	1493	1685	191	12.9
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	3506	3801	3747	- 54	- 1.4
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	848	730	595	- 135	- 18.5
Бусдыг амиа хорлоход хүргэх	128	123	385	262	213.0
Ашиглах	125	159	145	- 14	- 8.8
Танхайрах	937	931	576	- 355	- 38.1
Бусад	1595	1355	1494	139	10.3
БҮГД	13554	14037	15202	1165	8.3

2017 оны эхний 9 сард 26836 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 10471 (28.1%) хүнээр буурсан байна.

Зураг 49. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



⁵ 2017 оны 07-р сарын 01-ний өдрөөс эхлэн шинэ хэрэгжиж буй эрүүгийн хуулийн зарим заалт хүчингүй болсон тул өмнөх сараас багассан.


“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2017 оны IX сарын танилцуулга

Бүртгэгдсэн гэмт хэргийн 37.6 хувийг хулгайн, 24.6 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 11.1 хувийг залилан, 3.9 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг, 3.8 хувийг дээрмийн, 3.8 хувийг танхайн хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 33. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, дүүргээр, эхний 9 сард

Дүүрэг	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг			Өсөлт, бууралт 2016-2017	
	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	13 554	14 037	15 202	1 165	8.3
Багануур	241	223	197	- 26	- 11.7
Багахангай	20	20	31	11	55.0
Баянгол	2 096	2 453	2 158	- 295	- 12.0
Баянзүрх	3 298	3 213	4 002	789	24.6
Налайх	335	394	350	- 44	- 11.2
Сонгинохайрхан	2 401	2 337	2 723	386	16.5
Сүхбаатар	2 360	2 269	2 537	268	11.8
Чингэлтэй	1 756	1 857	1 929	72	3.9
Хан-Уул	1 047	1 271	1 275	4	0.3

Зураг 50. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, дүүргээр, эхний 9 сард



2017 оны эхний 9 сард бүртгэгдсэн гэмт хэргийн 8773 (57.7%) нь хөнгөн хэрэг, 3447 (22.7%) нь хүндэвтэр хэрэг, 2809 (18.5%) нь хүнд хэрэг, 173 (1.1%) нь онц хүнд хэрэг эзэлж байна.

Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь хамгийн өндөр (38.6%) нь Баянгол дүүрэгт байгаа бол, хамгийн бага (20.0%) нь Багахангай дүүрэгт байна.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн

тоо 7198 болж, өмнөх оны мөн үеэс 3857 (34.9%) хүнээр буурсан байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 1185 (16.5%) нь согтуугаар үйлдсэн, 900 (12.5%) нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, 430 (6.0%) нь урьд ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 393 (5.5%) нь хүүхэд, 1297 (18.0%) нь эмэгтэйчүүд байна.

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2017 оны IX сарын танилцуулга

Хүснэгт 34. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, эхний 9 сард

Дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс:		Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
		Сэжигтнийг илрүүлж ял сонгосон		
Нийслэлийн дүн	11 703	3 464		29.6
Багануур	114	30		26.3
Багахангай	20	4		20.0
Баянгол	1 353	522		38.6
Баянзүрх	3 193	785		24.6
Налайх	221	55		24.9
Сонгинохайрхан	2 279	607		26.6
Сүхбаатар	2 138	628		29.4
Чингэлтэй	1 501	530		35.3
Хан-Уул	884	303		34.3

Хүснэгт 35. Бүртгэсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, эхний 9 сард

Дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо			Үүнээс:		
				Хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо		
	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX
Нийслэлийн дүн	4 458	4 857	5 723	3 806	4 248	5 014
Багануур	62	55	56	47	45	51
Багахангай	2	3	4	1	2	2
Баянгол	476	664	519	389	544	390
Баянзүрх	1 190	1 186	1 690	1 024	1 014	1 464
Налайх	78	124	120	67	115	107
Сонгинохайрхан	954	829	1 125	880	758	1 038
Сүхбаатар	890	903	954	685	755	825
Чингэлтэй	547	732	822	469	687	741
Хан-Уул	259	361	433	244	328	396



ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Нийслэлийн хэмжээнд 2017 оны эхний 9 сард 225 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 43.6 хувиар бүүрсан байна. Нийт гамшигт хүчтэй шороон шуурга 1, аадар бороо, үер 3, мал амьтны халдварт галзуу өвчин 4, үхрийн хорт салст хатуурал 1, хүний үйл ажиллагаатай холбоотой 216 осол бүртгэгдсэн байна. Хүний үйл ажиллагаатай холбоотой осолд химийн бодисын 10 осол, усны 15 осол, барилгын 2 осол, бусад төрлийн 189 осол бүртгэгджээ. Гамшгийн улмаас 35 хүн амь насаа алдаж, 206 хүнийг аварч, гамшгийн уршгийг арилгах ажилд нийт 93.2 сая төгрөг зарцуулжээ.

Нийслэл хотод 2017 оны эхний 9 сард ахуйн 1928 гал түймэр гарч өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар бүүрсан байна. Гал түймрийн улмаас 15 хүн (үүнээс, хүүхэд 5) амь насаа алдаж, 20 хүн (үүнээс, хүүхэд 9) түлэгдэж гэмтсэн байна.


“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2017 оны IX сарын танилцуулга

Хүснэгт 36. Гал түймрийн тоо, он, дүүргээр


Дүүрэг	2012	2013	2014	2015	2016	2017	$\frac{2017}{2016}$ %
Нийслэлийн дүн	1 802	2 096	2 036	2 622	1 936	1 928	99.6
Багануур	19	25	27	40	35	25	71.4
Багахангай	4	1	5	9	6	3	50.0
Баянгол	250	341	318	350	331	277	83.7
Баянзүрх	428	457	478	636	479	440	91.9
Налайх	78	69	76	61	75	61	81.3
Сонгинохайрхан	345	413	388	570	407	432	106.1
Сүхбаатар	257	282	308	359	221	267	120.8
Хан-Уул	162	197	195	260	168	201	119.6
Чингэлтэй	259	311	241	337	214	222	103.7

Гал түймрийн аюулаас 627 хүн, 764 байшин барилга, 1.4 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварсан байна. Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал, цахилгаанаас 190, санамсаргүй байдлаас 1328, санаатай үйлдлээр 1, шалтгаан тогтоогдоогүй 91, бусад шалтгаанаар 318 гал түймэр гарчээ. Гал түймэрт гэр, орон сууц 622, барилга байгууламж, тоног төхөөрөмж 209, машин техник 99, малын хашаа, саравч 178, бусад төрлийн 820 объект өртсөн байна. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 1102, төрийн өмчийн 575, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 251 объект өртөж, нийт 4.6 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Зураг 51. Гал түймэр, шалтгаанаар



Зураг 52. Гал түймэр, байршлаар



Нийслэлийн Онцгой байдлын газраас 2017 оны эхний 9 сард 192 барилгын зураг төсөл, мөн ашиглалтад хүлээн авч буй 141 барилгад хяналт тавьж ажиллажээ. Түүнчлэн 5521 айл өрх, 7505 объектод үзлэг шалгалт хийж, 37866 галын зөрчил илрүүлж, 71 байгууллагын үйл ажиллагааг нь зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд 1994 заавал биелүүлэх албан шаардлага, 2724 мэдэгдэл хүргүүлж, 64.3 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.